

Улиастай сумын агаарын чанарын мэдээ

Агаарын чанарын суурин харууллын мэдээ





2022 он, 2023 оны 01, 11, 12 сар болон 2024 оны 01 сарын 18 өдрийн байдлаар:

- Азотын давхар ислийн агууламж
 - 2022 онд 11-54 мкг/м³ ;
 - 2023 онд 11-16 мкг/м³ ;
 - 2024 оны 01 сарын 18 өдрийн байдлаар 16 мкг/м³ байна.
- Хүхэрлэг хийн агууламж
 - 2022 онд 14-30 мкг/м³ ;
 - 2023 онд 20-26 мкг/м³ ;
 - 2024 оны 01 сарын 18 өдрийн байдлаар 26 мкг/м³ байна
- PM10 тоосонцрын агууламж
 - 2022 онд 43-60 мкг/м³ ;
 - 2023 онд 34-58 мкг/м³ ;
 - 2024 оны 01 сарын 18 өдрийн байдлаар 44 мкг/м³ байна.
- PM2.5 тоосонцрын агууламж
 - 2022 онд 37-57 мкг/м³ ;
 - 2023 онд 28-39 мкг/м³ ;
 - 2024 оны 01 сарын 18 өдрийн байдлаар 34 мкг/м³ байна.

MNS 4585:2016 стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан тохиолдол ажиглагдаагүй байна.

Агаарын чанарын явуул судалгааны мэдээ



Агаарын чанарын явуул судалгааг хүйтний буюу галлагаатай улиралд багуудад тодорхой цэгт хийж гүйцэтгэж байна.

- Хүхэрлэг хий
 - 01 сард 13-44 мкг/м³ ;
 - 11 сард 5-55 мкг/м³ ;
 - 12 сард 9-39 мкг/м³ агууламжтай байна.
- Азотын давхар исэл
 - 01 сард 13-33 мкг/м³ ;
 - 11 сард 14-66 мкг/м³ ;
 - 12 сард 10-33 мкг/м³ агууламжтай байна.
- PM10 тоосонцрын агууламж
 - 01 сард 29-169 мкг/м³ буюу 2024 онд Жаргалант болон Чигэстэй багуудад хүлцэх агууламжаас 1.5-1.7 дахин давсан байна.
 - 11 сард 28-218 мкг/м³ буюу 2022 онд Чигэстэй багт 1.3 дахин, 2023 онд Чигэстэй болон Жаргалант багуудад хүлцэх агууламжаас 1.5-2.2 дахин давсан байна.
 - 12 сард 36-160 мкг/м³ буюу 2022 онд богдын гол багт 1.6 дахинд, 2023 онд Богдын гол болон Чигэстэй багуудад хүлцэх агууламжаас 1.1-1.5 дахин давсан байна.

Уурын зуухны судалгааны мэдээ

Завхан аймгийн Улиастай сумд томоохон зуух ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжид жил болгон тогтмол хугацаанд агаарын хяналт-шинжилгээ хийн гүйцэтгэж байна.

Багуудыг тоон утгаар кодлосон байдлын тайлбар:

- 1- Товцог баг 3- Богдын гол баг 5- Жаргалант баг
2- Жинст баг 4- Чигэстэй баг



Хүхэрлэг хий:

- 2022 онд 6-79 мкг/м³ агууламжтай буюу бохирдуулагчийг агаарт хамгийн их, бага агууламжтай ялгаруулж буй зуух нь Жинст багт байрлаж байна.
- 2023 онд 15-78 мкг/м³ агууламжтай буюу бохирдуулагчийг агаарт хамгийн бага ялгаруулж буй нь Товцог багт, хамгийн их ялгаруулж буй нь Жинст багт байна.



Азотын давхар исэл:

- 2022 онд 8-43 мкг/м³ агууламжтай буюу бохирдуулагчийг агаарт хамгийн их агууламжтай ялгаруулж буй зуух нь Богдын гол багт, хамгийн бага агууламжтай ялгаруулж буй нь Жаргалант багт байрлаж байна.
- 2023 онд 10-55 мкг/м³ агууламжтай буюу бохирдуулагчийг агаарт хамгийн их агууламжтай ялгаруулж буй зуух нь Жинст багт, хамгийн бага агууламжтай ялгаруулж буй нь Товцог багт байрлаж байна.



PM₁₀ тоосонцор:

- 2022 онд 20-391 мкг/м³ агууламжтай буюу бохирдуулагчийг агаарт хамгийн их агууламжтай ялгаруулж буй зуух нь Жинст багт, хамгийн бага агууламжтай ялгаруулж буй нь Жаргалант багт байрлаж байна.
- 2023 онд 26-520 мкг/м³ агууламжтай буюу бохирдуулагчийг агаарт хамгийн их агууламжтай ялгаруулж буй зуух нь Богдын гол багт, хамгийн бага агууламжтай ялгаруулж буй нь Жинст багт байрлаж байна.